



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу 3, Засгийн газрын IV байр,
Утас: 26 04 37, Факс: (976) 6226 3230,
E-mail: info@audit.gov.mn, http://www.audit.mn

2017. 03. 15 № 3/463

танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.3, 15 дугаар зүйлийн 15.1.1, 15.1.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Хилийн 0119 дүгээр анги” ТӨААТҮГ-ын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, мөнгөн гүйлгээний, өмчийн өөрчлөлтийн тайлан болон холбогдох тодруулга бүхий санхүүгийн тайланд аудит хийв.

Үүрэг хариуцлагын талаархи мэдээлэл

“Хилийн 0119 дүгээр анги” ТӨААТҮГ-ын удирдлага нь тайлант хугацааны санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (СТОУС), Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт (НББОУС), түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмын дагуу үнэн зөв бэлтгэж, тайлагнах үүрэг хариуцлага хүлээнэ.

“Хилийн 0119 дүгээр анги” ТӨААТҮГ-ын 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан нь үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Санал дүгнэлтийн үндэслэл

Бид аудитыг Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журмын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, журам нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар “Хилийн 0119 дүгээр анги” ТӨААТҮГ-ын санхүүгийн тайлан, түүний тодруулга дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, программ хангамж, дотоод хяналтын систем, гол хууль тогтоомжуудын мөрдөлт, удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан болно.

Өглөгийн үлдэгдэлтэй 34 байгууллагын 686,124.3 мянган төгрөгийн жилийн эцсийн үлдэгдлийг баталгаажуулаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь хэсэгт заасан “Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, Барилгын ажил дуусч акт гарсан үед, худалдсан орон сууцыг худалдан авагчтай гэрээ хийж, хүлээлгэн өгсөн тухай


бүр 5,285,471.7 мянган төгрөгийн борлуулалтын орлогоор хүлээн зөвшөөрч бүртгээгүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккрузал сууриар хөтөлнө" гэсэн заалттай нийцэхгүй байгаа зөрчил нь оршин байх, үнэн зөв байх, тохиолдсон байх гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан материаллаг алдаагүй эсэхэд санал дүгнэлт өгөх хангалттай үндэслэл болно гэдэгт итгэлтэй байна.

Хязгаарлалттай санал дүгнэлт

Бидний дүгнэлтээр дээрхи алдаа, зөрчлөөс бусад зүйлсийн хувьд "Хилийн 0119 дүгээр анги" ТӨААТҮГ-ын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан болон санхүүгийн тайлангийн тодруулгуудыг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, НББОУС, СТОУС, түүнд нийцүүлж Сангийн сайдын баталсан заавар, журмын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ



УАГ
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

ХИЛИЙН ЦЭРГИЙН 0119 -Р АНГИ ТӨААТҮГ-ЫН 2016 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

АУДИТЫН ТАЙЛАН

Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл
дараахи хаягаар харилцана уу:

Монгол Улсын Үндэсний Аудитын газар
Засгийн газрын IY байр
Улаанбаатар-46 Бага тойруу 6
Web: www.mnao.gov.mn

УАГ Санхүүгийн аудитын газрын
Захирал Ц.Наранчимэг
Утас: 261663
И-мэйл: www.audit.gov.mn

Аудитын менежер Я.Самбууням
Утас: 260512
И-мэйл: www.audit.gov.mn

Аудитор Н.Нямдаваа
Утас: 260512
И-мэйл: www.audit.gov.mn

Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн:
“Бэст фортуна Аудит” ХХК
Утас: 324438
И-мэйл: fortune_audit@yahoo.com

Захирал: Ж.Оюунцэцэг
Утас: 89116465, 98056465
И-мэйл: oyuntsetseg_cpa@yahoo.com

Аудитын багийн ахлагч:
Аудитор: Н.Одончимэг
Утас: 98006465
И-мэйл: d.odnoo@yahoo.com

Хавсралт 1: Агуулга

Хавсралт 2: Аудитын гэрчилгээ

Хавсралт 3: Менежментийн захидал

Хавсралт 4: Аудит хийгдсэн санхүүгийн
тайлан

Агуулга

Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл	3
Байгууллагын хууль эрх зүйн орчин	3
Байгууллагын зорилго, үйл ажиллагаа	4
Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, сорилууд түүний үр дүн	4
Материаллаг байдал	5
Дотоод хяналт	5
Борлуулалтын орлого, төсвийн татаас, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар	5
Шилэн дансны мэдээлэл	5
Олж тогтоосон гол эрсдлүүд	6-7
Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар	7
Аудитаар илэрсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар	7-9
Залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар	9
Анхаарал татахуйц бусад чухал асуудал	9
Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд	10
Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл	10-11
Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	11
Дүгнэлт	11

1. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл:

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 9.8, Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 1.2, 18 дугаар зүйлийн 5 дахь заалтуудыг үндэслэн Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд “Хилийн цэргийн 0119-р анги” ТӨААТҮГ-ын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн санхүүгийн тайланд “Бэст фортуна аудит” ХХК гэрээгээр аудит хийлээ.

Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хуулийн хүрээнд Аудитын Олон Улсын Стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө хөтөлбөрийн дагуу явуулав.

“Хилийн цэргийн 0119-р анги” ТӨААТҮГ-ын 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилго байв.

Тухайн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, СТОУС-тай нийцүүлж материаллаг алдаагүй үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь “Бэст фортуна Аудит” ХХК-ийн үүрэг юм.

“Хилийн цэргийн 0119-р анги” ТӨААТҮГ-ын удирдлага санхүүгийн тайлангаа Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартын дагуу үнэн зөв бэлтгэн гаргах үүрэгтэй.

“Хилийн цэргийн 0119-р анги” ТӨААТҮГ-ын 2016 оны завсрын аудитыг 2016 оны 09 дүгээр сарын 20-ноос 2016 оны 10 дугаар 17-ны хооронд, жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитыг 2017 оны 02 дугаар сарын 01-нээс 2017 оны 03 дугаар сарын 15-ны хооронд хийхээр төлөвлөн “Бэст фортуна Аудит” ХХК-ийн аудитын баг хэрэгжүүлэв. /ТАБ-СТА-А-9/

“Хилийн цэргийн 0119-р анги” ТӨААТҮГ нь 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг 2017 оны 02 дугаар сарын 09-нд “Бэст фортуна Аудит” ХХК-нд ирүүлсэн байна.

“Бэст фортуна Аудит” ХХК нь жилийн эцсийн аудитыг 2017 оны 02 дугаар сарын 10-наас 3 дугаар сарын 06-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2017 оны 3 дугаар сарын 17-нд “Хилийн цэргийн 0119-р анги” ТӨААТҮГ-ын удирдлагад гардуулна.

2. Байгууллагын хууль эрх зүйн орчин:

“Хилийн цэргийн 0119-р анги” ТӨААТҮГ-ын удирдлага нь Компаний тухай хууль, Хилийн тухай хууль, Барилгын тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиудын хүрээнд үйл ажиллагаа явуулж байна. Тайлангийн хугацаанд тухайн байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг гол хууль тогтоомж, түүнд нийцүүлэн гаргасан журам зааварт өөрчлөлт орсон ба Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль 2016 оны 1 дүгээр сарын 1-нээс шинэчлэгдэн мөрдөгдөж байна.

3. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа:

Хилийн цэргийн 0119-р анги нь 1964 онд ротын зохион байгуулалттайгаар НАХЯ-ны системийн байгууллагуудын барилга засварын ажлыг хийж гүйцэтгэх үүрэгтэйгээр байгуулагдсан. 1995 оноос Төрийн Өмчит Аж Ахуйн Тооцоот Үйлдвэрийн газар болж БУ-17-00142/06 тоот “Барилга угсралтын ажил эрхлэх тусгай зөвшөөрөл”-тэйгээр аж ахуйн тооцоонд шилжин өөрөө өөрийгөө санхүүжүүлэх зарчмаар ажиллах болсон байна. Тус анги нь төрийн нууцын зэрэглэлд хамаарах барилга обектууд барьж угсрах, засварлах үүрэгтэйгээс гадна мэргэжлийн ажиллагсдыг ажлын байраар тогтмол хангах, байгууллагын санхүүгийн хувьд тогтмол орлоготой байх зорилгоор иргэний барилгын салбарт орон сууцны барилга угсралтын үйл ажиллагааг 2010 оноос явуулж эхэлсэн байна.

Улаанбаатар хотын СХД-ын 7-р хорооны нутаг дэвсгэрт байрлах өөрийн аж ахуйн зориулалттай 1.8 га газарт 2010 оноос 2012 он хүртэл хугацаанд “Хилчин хотхон”-ны орон сууцны 692 айлын орон сууц, Нийслэлийн БЗД-ийн 8-р хорооны нутаг дэвсгэрт 2012-2015 оны хугацаанд “Харуул Алтай” хотхоны 786 айлын орон сууцны барилгын ажлыг гүйцэтгэсэн байна. 2015 онд Төрийн банкнаас 1.7 тэрбум төгрөгийн зээл авч “Харуул Алтай” орон сууцны хотхоны үргэлжлэл 26 айлын орон сууцны, Дорноговь аймгийн Хатанбулаг сум дахь Хилийн дугаар ангийн уурын зуух, дэд өртөө, усан сан, гадна дулаан, цэвэр, бохир ус, цахилгааны ажил, Хууль зүйн сайдын тушаалаар Үндэсний төв архивын нэгдсэн барилгын ажлыг тус тус гүйцэтгэсэн байна. Мөн Төв аймаг дахь Бугын сангийн аж ахуйд Хил хамгаалах байгууллагын Тусгай бэлтгэл, нөхөн сэргээлтийн төвийн барилгын ажлын зураг гаргуулан ажлыг гүйцэтгэж байгаа ба 2016 онд ХСИС-ын ажилчдын хүүхдийн цэцэлэгийн засварын ажил, Дорноговь аймгийн Хатанбулаг дахь хилийн цэргийн дугаар ангийн барилга, Увс аймгийн Баруун туруун суманд хилийн цэргийн дугаар ангийн барилгыг улсын төсвийн хөрөнгөөр, Үндэсний цэцэрлэгт хүрээлэнгийн талбайн тохижилтын ажлыг хилийн цэргийн ангиудын хандиваар тус тус гүйцэтгэж ашиглалтанд өгсөн байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 18.1-д “Аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын өдөр тутмын үйл ажиллагааг үйлдвэрийн газрын захирал удирдана” гэж заасны дагуу Хилийн 0119 дүгээр анги ТӨААТҮГ-ын захирагч Х.Лхагвасүрэн 2016 оны 09 дүгээр сарын 29 хүртэл, Н.Алтанбаганана 2016 оны 12 дугаар сарын 31-нийг дуустал захирлаар тус тус ажилласан байна.

4. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, сорилууд түүний үр дүн:

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, СТОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг шалгуур болгон ашигласан болно. Аудитаар “Хилийн цэргийн 0119-р анги” ТӨААТҮГ-ын 2016 оны санхүүгийн тайланд дүгнэлт өгөх үүднээс санхүүгийн тайлан нь материаллаг алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд уламжлалт болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжуулав. /ТАБ-СТА-А-5/

Санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, материаллаг дүнтэй зарим гүйлгээнүүдийг түүвэрчилсэн байдлаар аудитын 20 горим, сорил гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Тухайн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, системтэй танилцахад санхүүгийн үйл ажиллагаанд хэрэглэгдэх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг байгаа боловч байгууллагын онцлогт тохирсон борлуулалтын орлого, урьдчилж орсон орлого, урьдчилж төлсөн зардал, авлагын дансны бодлого, горим, дансны бичилт тодорхой биш байгаагаас мөрдөлт нь хангалттай биш байна.

“Хилийн цэргийн 0119-р анги” ТӨААТҮГ-ын санхүүгийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа компьютерийн системийн үйл ажиллагаатай асуулга явуулах, програмд нэвтрэх зэрэг аргаар танилцан түүний нарийн төвөгтэй байдлын үнэлгээ хийхэд мэдээллийн технологийн мэргэжилтэнг оролцуулах шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэсэн болно. /ТАБ-СТА-В-2/

Санхүүгийн үйл ажиллагааг бүртгэх, боловсруулах үйл ажиллагааг “Винница” санхүүгийн програмыг ашиглан санхүүгийн тайлан бэлтгэж байсан ба манай компани өмнөх аудитаар зөвлөсний дагуу Даймонд санхүүгийн програм нэвтрүүлэн аргачлалын дагуу санхүүгийн тайланг бэлтгэн гаргасан байна.

5. Материаллаг байдал

Төлөвлөлтийн шатанд материаллаг байдлыг тооцохдоо 2015 оны борлуулсан бүтээгдэхүүний өртгөөр суурь үзүүлэлт болгон сонгож 1 хувиар буюу 92,420.3 мянган төгрөгөөр тооцсон ба гүйцэтгэлийн шатанд 2016 оны нийт зардлыг суурь болгон сонгож 2 хувиар тооцон 59,171.5 мянган төгрөгөөр тогтоов. Материаллаг байдлын суурийг өөрчилсөн, хувийг 2 хувиар тооцсон шалтгаан нь тайлангийн жилд борлуулалтын орлого өмнөх онуудаас буурсан, тогтмол зардал буураагүйтэй холбоотой болно.

6. Дотоод хяналт

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хийсэн. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм. “Хилийн цэргийн 0119-р анги” ТӨААТҮГ-ын дотоод хяналтын эрсдлийн 12 эрсдэл үр нөлөөтэй, 22 эрсдэл үр нөлөөгүй гэж тооцсон. /ТАБ-СТА-А-4-өөс үзнэ үү/

7. Борлуулалтын орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар

“Хилийн цэргийн 0119-р анги” ТӨААТҮГ нь 2016 онд 2,956,579.5 мянган төгрөгийн борлуулалтын орлого, бусад орлого 463.8 мянган төгрөг, борлуулсан бүтээгдэхүүний өртөг 2,120,884.7 мянга, удирдлагын зардал 784,226.8 мянга, борлуулалт маркетингийн зардал 357,3 мянга, бусад зардал 53,107.3 мянган төгрөгийн зардал тус тус тайлагнаж 1,532.8 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан байна. Харуул-Алтай хотхоны халаалт, ус, цахилгааны болон бусад ашиглалтын зардал 291,167.4 мянган төгрөгийг Удирдлагын зардалд бүртгэж аудиторын зөвлөмжийг хэрэгжүүлээгүй ба шалтгаан нь ерөнхий нягтлан бодогчийн өмнөх хаалтыг задлан санхүүгийн тайлан засварлах боломжгүй /нас барсан/ гэж тайлбарласан болно. 2016 онд өмнөх онуудаас барилгын ажил багассан нь алдагдалтай ажиллахад нөлөөлсөн байна.

8. Шилэн дансны мэдээлэл

Тус байгууллага нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

Шилэн дансны хуультай холбоотой байж болох эрсдэлийн хүчин зүйлсийг судлах явцад 1 горим сорил хэрэгжүүлэв. Байгууллагын цахим хуудсанд байгууллагын мэдээлэлүүдийг оруулсан байна.

9. Олж тогтоосон гол эрсдлүүд

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 34 эрсдлийг тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нийт 20 горим, сорил гүйцэтгэж доорхи эрсдлүүдийг олж тогтоов. /ТАБ-СТА-В-3-аас үзнэ үү/ Үүнд:

- a) Мөнгөн хөрөнгийн данснаас авлага, өглөгийн дансаар дамжуулахгүй дуусаагүй үйлдвэрлэл, борлуулсан бүтээгдэхүүний өртөг дансанд бичсэн нь зардлыг буруу тайлагнаж улмаар санхүүгийн үр дүнд нөлөөлөх, тооцооны үлдэгдлийн хяналтыг сулруулах,
- b) Авлага, өглөгийн үлдэгдэлтэй байгууллага, хувь хүмүүстэй тооцоо хийж үлдэгдлийг бүрэн баталгаажуулаагүй байгаа нь санхүүгийн тайлан дахь үлдэгдлийн үнэн зөв байдал нотлогдохгүй болох,
- c) Материал ханган нийлүүлэгчдийг сонгон шалгаруулалтаар сонгоогүй, материал нийлүүлэгч бүх байгууллага хувь хүмүүстэй гэрээ бүрэн хийгээгүй, НӨАТ төлөгч байгууллагыг аль болохоор түлхүү сонгоогүй зэрэг нь үнийн сонголт, НӨАТ-ын байдалд сөргөөр нөлөөлөх,
- d) Борлуулалтын орлогыг хэрэгжсэн үед нь хүлээн зөвшөөрөөгүйгээс татвар хойшлох, алданги, торгууль тооцогдох,
- e) Урьдчилж төлсөн зардал (дуусаагүй үйлдвэрлэл)-аас борлуулсан бүтээгдэхүүний өртөг дансанд СТОУС-ын **орлого, зардлын зохицох зарчим**-ыг баримтлаагүйгээс санхүүгийн эцсийн үр дүн буруу илэрхийлэгдэх
- f) Борлуулсан бүтээгдэхүүний өртөгт бүртгэх зардлыг удирдлагын зардалд бүртгэх нь мэдээлэл хэрэглэгчдэд санхүүгийн тайлангийн үзүүлэлтийг буруу ойлгуулах,
- g) Барилгын ажлыг объект бүрээр урьдчилж төлсөн зардал дансанд бүртгээгүй, дуусаагүй үйлдвэрлэл дансанд агилалгүйгээр бүртгэсэн нь объект бүрээр үр дүнгийн шинжилгээ хийхэд хүндрэлтэй байдал бий болгоно.

10. Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар

Аудиторын зөвлөмжийн дагуу 2015 онд борлуулсан орон сууцны 1,889,280.0 мянган төгрөгийн авлагыг 2016 оны 1 дүгээр сарын 02-нд нөхөн үүсгэж нягтлан бодох бүртгэлд тусгасан байна.

11. Аудитаар илэрсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар

Санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн гол асуудлуудыг дараах заалтуудад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

Доорхи алдаа, зөрчлүүд нь санхүүгийн тайлангийн Оршин байх, Эрх үүрэг, Үнэн зөв байх, Иж бүрэн байх, Тохиолдсон байх, Хэмжилт гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

1. Өглөгийн үлдэгдэлтэй 34 байгууллагын 686,124.3 мянган төгрөгийн жилийн эцсийн үлдэгдлийг баталгаажуулаагүй байгаа нь **Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь хэсэгт заасан “Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”** гэсэн заалттай нийцэхгүй байна.

- ✓ **Шийдвэрлэсэн нь:** Аудитын явцад 17 байгууллагуудын үлдэгдлийг баталгаажуулсныг аудитын ажлын баримтанд авсан тооцоо нийлээгүй үлдсэн байгууллага, хувь хүмүүстэй 2017 оны эхний хагаст багтаан үлдэгдлийг баталгаажуулах зөвлөмж өгөв.

2. Барилгын ажил дуусч акт гарсан үед, худалдсан орон сууцыг худалдан авагчтай гэрээ хийж, хүлээлгэн өгсөн тухай бүр тус тус орлогоор хүлээн зөвшөөрч нягтлан бодох бүртгэлд бүртгээгүй, Урьдчилж орсон орлогын үлдэгдэл өмнөх оноос 5,285,471.7 мянган төгрөгөөр өссөн нь **Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д “Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккрузал сууриар хөтөлнө”** гэсэн заалттай нийцэхгүй байна.

- ✓ **Шийдвэрлэсэн нь:** Урьдчилж орсон орлого дансны үлдэгдлийг объект бүрээр ангилах, 3,402,146.5 мянган төгрөгийг 2017 оны 1 дүгээр улирлаас эхлэн орлогоор хүлээн зөвшөөрч бүртгэх зөвлөмж өгөв.

3. Урьдчилж төлсөн зардал (дуусаагүй үйлдвэрлэл)-аас борлуулсан бүтээгдэхүүний өртөг дансанд СТОУС-ын **орлого, зардлын зохицох зарчим**-ыг баримтлаагүйгээс санхүүгийн эцсийн үр дүн 3,036,566.1 мянган төгрөгөөр буруу илэрхийлэгдсэн

- ✓ **Шийдвэрлэсэн нь:** Борлуулсан бүтээгдэхүүний өртөгийг бууруулан аудитын хугацаанд санхүүгийн тайланг дахин гаргаж залруулав.

4. Борлуулсан бүтээгдэхүүний өртөгт бүртгэх 291,167.4 мянган төгрөгийн зардлыг удирдлагын зардалд бүртгэсэн.

- ✓ **Шийдвэрлэсэн нь:** Өмнө нь ажиллаж байсан ерөнхий нягтлан бодогчийн ажлыг засах боломжгүй гэсэн тайлбар гаргасныг үндэслэн хойшид дээрх зөрчлийг давтахгүй байх талаар зөвлөмж өгсөн.

5. Барилгын ажлыг объект бүрээр урьдчилж төлсөн зардал дансанд бүртгээгүй, дуусаагүй үйлдвэрлэл дансанд ангилахгүйгээр бүртгэсэн нь объект бүрээр үр дүнгийн шинжилгээ хийх, дотоод хяналтад хүндрэлтэй байдал бий болгосон.

Шийдвэрлэсэн нь: Барилгын зардлыг урьдчилж төлсөн зардал дансанд объект нэг бүрээр дансны дэд ангилал үүсгэн шилжүүлэн бүртгэх зөвлөмж өгсөн

Аудитаар илэрсэн бүх асуудлыг “Хилийн цэргийн 0119-р анги” ТӨААТҮГ-ын удирдлага авч үзэж, судлан шийдвэрлэж аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчлийг хүлээн

зөвшөөрч 3,036,566.1 мянган төгрөгийн зөрчилд залруулга хийж санхүүгийн тайланг засварлан гаргасан ба бусад зөвлөмжүүдийг 2017 онд хэрэгжүүлэх тухай ярилцлагын тэмдэглэлээр баримтжуулсан ба хэрэгжилтийг дараагийн санхүүгийн тайлангийн аудитаар дахин авч үзнэ.

12. Залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар

Бараа материалын бүлэгт дуусаагүй үйлдвэрлэл дансанд бүртгэж байгаа зардлыг 2017 оны 1 дүгээр улирлын санхүүгийн тайлангаар Урьдчилж төлсөн зардал дансанд, объект бүрээр бүртгэх талаар зөвлөмж өгсөн ба дээрх алдааг санхүүгийн тайлангийн үр дүнд нөлөөгүй гэж үзэв.

13. Анхаарал татахуйц бусад чухал асуудал

Анхаарал татахуйц бусад асуудал байгаагүй болно.

14. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд

1. Урьдчилж орсон орлогын он дамжсан үлдэгдлийг хүлээн зөвшөөрсөн байдал
2. Нягтлан бодох бүртгэлийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.1. **"Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу нягтлан бодох бүртгэл хөтөлж"** гэсэн заалтын дагуу үнэн зөв хөтөлсөн эсэхийг дараагийн аудитаар дахин авч үзнэ.

15. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл

Аудитаар нийт 9,299,329.5 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн ба үүнээс 3,036,566.1 мянган төгрөгийн алдааг залруулсан, залруулагдаагүй 291,167.4 мянган төгрөгийн алдааг байгууллагын зүгээс шалтгаалаагүй тухай тайлбар, баримтжуулалт, аудитын явцад зөрчлийг залруулсан байдал болон санхүүгийн үр дүн, дансдын үлдэгдэлд материаллаг нөлөө үзүүлээгүй зэргийг харгалзан 5 зөвлөмж өгч,

-борлуулалтын орлого хүлээн зөвшөөрөөгүй 5,285,471.7 мянга,

-өглөгийн тооцоо нийлж үлдэгдэл баталгаажуулаагүй 686,124.3 мянга,

нийт 5,971,596.0 мянган төгрөгийн зөрчилд Хязгаарлалттай санал дүгнэлт өгөх санал оруулсан болно.

16. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

2015 оны санхүүгийн тайлангийн аудитаар "Бэст фортуна Аудит" ХХК-аас өгөгдсөн 10 зөвлөмжөөс 2, 2016 оны санхүүгийн тайлангийн завсрын аудитаар өгөгдсөн 7 зөвлөмжөөс 2 зөвлөмж тус тус хэрэгжээгүй ба шалтгааныг зөвлөмжийн биелэлтийн тайланд тайлбарласан байна.

17. Санал дүгнэлтийн үндэслэл

Өглөгийн үлдэгдэлтэй 34 байгууллагын 686,124.3 мянган төгрөгийн жилийн эцсийн үлдэгдлийг баталгаажуулаагүй нь **Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь хэсэгт заасан "Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах"**, Барилгын ажил дуусч акт гарсан үед, худалдсан орон сууцыг худалдан авагчтай гэрээ хийж,

хүлээлгэн өгсөн тухай бүр 5,285,471.7 мянган төгрөгийн борлуулалтын орлогоор хүлээн зөвшөөрч бүртгээгүй нь **Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д “Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккрузл сууриар хөтөлнө”** гэсэн заалттай нийцэхгүй байгаа зөрчил нь **оршин байх, үнэн зөв байх, тохиолдсон байх** гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

18. Хязгаарлалттай санал дүгнэлт

Бидний дүгнэлтээр дээрхи алдаа, зөрчлөөс бусад зүйлсийн хувьд “Хилийн 0119-р анги” ТӨААТҮГ-ын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн байдал, орлогын тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлангууд нь СТОУС, түүнд нийцүүлэн гаргасан Сангийн сайдын тушаалаар батлагдсан нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой журам, зааврын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн байна.



ХИЛИЙН ЦЭРГИЙН 0119-Р АНГИ ТӨААТҮГ-ЫН 2016 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл
дараахи хаягаар харилцана уу:

Монгол Улсын Үндэсний Аудитын
газар
Засгийн газрын IY байр
Улаанбаатар-46 Бага тойруу 6
Web: www.mnao.gov.mn

YAГ Санхүүгийн тайлангийн газрын
Захирал Ц.Наранчимэг
Утас: 261663
И-мэйл: www.audit.gov.mn

Аудитын менежер Я.Самбууням
Утас: 260512
И-мэйл: www.audit.gov.mn

Аудитор Н.Нямдаваа
Утас: 260512
И-мэйл: www.audit.gov.mn

Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн:
“Бэст фортуна Аудит” ХХК
Утас: 324438
И-мэйл: fortune_audit@yahoo.com

Захирал: Ж.Оюунцэцэг
Утас: 89116465, 98056465
И-мэйл: Oyuntsetseg_cpa@yahoo.com

Аудитын багийн ахлагч:
Аудитор: Н.Одончимэг
Утас: 98006465
И-мэйл: n.odnoo@yahoo.com

МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Тэргүүлэх ач холбогдол № 1

Асуудал 1 Урьдчилж орсон орлого

Тэргүүлэх ач холбогдол № 2

Асуудал 1 Авлага, өглөг

Асуудал 2 Санхүүгийн тайлагнал

Менежментийн захидал

Үндэсний аудитын газар аудитын явцад илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг “Хилийн 0119-р анги” ТӨААТҮГ-ын удирдлагад зориулан бэлтгэсэн бөгөөд түүнд хяналтын сул тал, горимыг өөрчлөх замаар хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгасан болно.

Энэхүү менежментийн захидлын агуулга АОУС-ын дагуу хийгддэг ТАБ-ын аудитын горимоос урган гарсан болно. Бидний хэрэгжүүлсэн горим сорил нь санхүүгийн тайлангийн санал дүгнэлт гаргахад зориулагдсан.

Тиймээс аудитын зөвлөмж нь дахин хяналт хийх үеийн нөхцөл байдлын талаархи бидний үнэлэлт дүгнэлтийг тусгаж байгаа болно.

Төрийн аудитын байгууллага энэхүү зөвлөмжийг танай байгууллагын бүртгэл, тайлагнал, хяналтын үйл ажиллагааг сайжруулах зорилготой бөгөөд харин зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад хамтран ажилласан “Хилийн цэргийн 0119-р анги” ТӨААТҮГ-ын захирагч хурандаа А.Лхагвасүрэн, болон санхүүгийн ажилтнуудад талархал илэрхийлье.

Аудитын ажиглалт

1. Барилгын ажил дуусч акт гарсан үед, худалдсан орон сууцыг худалдан авагчтай гэрээ хийж, хүлээлгэн өгсөн тухай бүр тус тус орлогоор хүлээн зөвшөөрч нягтлан бодох бүртгэлд бүртгээгүй Урьдчилж орсон орлогын үлдэгдэл өмнөх оноос 5,285,471.7 мянган төгрөгөөр өссөн нь **Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д “Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккрузл сууриар хөтөлнө”** гэсэн заалттай нийцэхгүй байна.

Эрсдэл

Борлуулалтын орлогыг хэрэгжсэн үед нь хүлээн зөвшөөрөөгүйгээс татвар хойшлох, алданги, торгууль тооцогдох,

/Эрх үүрэг, Үнэлгээ/

Аудитын зөвлөмж

Урьдчилж орсон орлого дансны үлдэгдлийг объект бүрээр ангилах, 3,402,146.5 мянган төгрөгийг 2017 оны 1 дүгээр улирлаас эхлэн орлогоор хүлээн зөвшөөрч бүртгэх

Үйлчлүүлэгчийн хариу

Зөвлөмжийг хэрэгжүүлэн хуулийг баримтлан ажиллана

Аудитын ажиглалт

1. Өглөгийн үлдэгдэлтэй 34 байгууллагын 686,124.3 мянган төгрөгийн жилийн эцсийн үлдэгдлийг баталгаажуулаагүй байгаа нь **Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь хэсэгт заасан “Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”** гэсэн заалттай нийцэхгүй байна

Эрсдэл

Байгууллага хоорондын тооцоо тодорхойгүй болох, хянахад хүндрэл учрах, үлдэгдэл буруу илэрхийлэгдэх

/ Эрх үүрэг, Үнэн зөв, Оршин байх /

Аудитын зөвлөмж

Аудитын явцад зарим байгууллагуудын үлдэгдлийг баталгаажуулсаныг аудитын ажлын баримтанд авсан тооцоо нийлээгүй үлдсэн байгууллага хувь хүмүүстэй 2017 оны эхний хагаст багтаан үлдэгдлийг баталгаажуулах

Үйлчлүүлэгчийн хариу

Зөвлөмжийг хэрэгжүүлнэ

Аудитын ажиглалт

1. Урьдчилж төлсөн зардал (дуусаагүй үйлдвэрлэл)-аас борлуулсан бүтээгдэхүүний өртөг дансанд СТОУС-ын **орлого, зардлын зохицох зарчим**-ыг баримтлаагүйгээс санхүүгийн эцсийн үр дүн 3,036,566.1 мянган төгрөгөөр буруу илэрхийлэгдсэн

2. Борлуулсан бүтээгдэхүүний өртөгт бүртгэх 291,167.4 мянган төгрөгийн зардлыг удирдлагын зардалд бүртгэсэн.

3. Барилгын ажлыг объект бүрээр урьдчилж төлсөн зардал дансанд бүртгээгүй, дуусаагүй үйлдвэрлэл дансанд ангилахгүйгээр бүртгэсэн нь объект бүрээр үр дүнгийн шинжилгээ хийх, дотоод хяналтад хүндрэлтэй байдал бий болгосон

Эрсдэл

а) Санхүүгийн эцсийн үр дүн буруу илэрхийлэгдэх

б) Мэдээлэл хэрэглэгчдэд санхүүгийн тайлангийн үзүүлэлтийг буруу ойлгуулах, объект бүрээр үр дүнгийн шинжилгээ хийхэд хүндрэлтэй байдал бий болгоно.

/Тохиолдсон байх, Эрх үүрэг, Үнэн зөв/

Аудитын зөвлөмж

1. Аудитын явцад залруулга хийх зөвлөмж өгсний санхүүгийн тайланг дахин гаргасан ба хойшид зөрчлийг давтахгүй байх

2. Зардлыг ангилалын дагуу зөв бүртгэж байх

3. Барилгын зардлыг урьдчилж төлсөн зардал дансанд объект нэг бүрээр дансны дэд ангилал үүсгэн шилжүүлэн бүртгэх

Үйлчлүүлэгчийн хариу

Зөвлөмжийг хэрэгжүүлж санхүүгийн тайланд засварласан ба хойшид зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.

"ХИЛИЙН ЦЭРГИЙН 0119 ДУГААР АНГИ" ТӨААТҮГ

2016 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨРХ
АУДИТЛАГДСАН ТАЙЛАН ТЭНЦЭЛ

(төгрөгөөр)

Үзүүлэлтүүд		2016-12-31	
	Аудитлагдаагүй	Залруулга	Аудитлагдсан
ХӨРӨНГӨ			
Эргэлтийн хөрөнгө			
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	1,310,750.56		1,310,750.56
Дансны авлага	995,720,153.20		995,720,153.20
Татвар, НДШ-ийн авлага			-
Бусад авлага	72,320,519.71		72,320,519.71
Бусад санхүүгийн хөрөнгө			-
Бараа материал	7,016,267,838.21	(536,229,866.91)	6,480,037,971.30
Урьдчилж төлсөн зардал/тооцоо			-
буй эргэлтийн бус хөрөнгө		3,572,795,974.00	3,572,795,974.00
Эргэлтийн хөрөнгө	8,085,619,261.68	3,036,566,107.09	11,122,185,368.77
Эргэлтийн бус хөрөнгө			
Үндсэн хөрөнгө	782,373,411.11		782,373,411.11
Биет бус хөрөнгө	9,750,607.26		9,750,607.26
Бусад эргэлтийн бус хөрөнгө			-
Эргэлтийн бус хөрөнгө	792,124,018.37		792,124,018.37
Нийт хөрөнгийн дүн	8,877,743,280.05	3,036,566,107.09	11,914,309,387.14
ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧИЙН ӨМЧ			
Өр төлбөр			
Богино хугацаат өр төлбөр			
Дансны өглөг	1,661,355,382.15		1,661,355,382.15
Цалингийн өглөг	78,608,590.00		78,608,590.00
Татварын өглөг	106,247,638.76		106,247,638.76
ЭМ, НДШ-ийн өглөг	12,562,178.93		12,562,178.93
Богино хугацаат зээл	587,312,975.19		587,312,975.19
Бусад богино хугацаат өр төлбөр			-
Урьдчилж орсон орлого	6,393,931,122.54		6,393,931,122.54
өр төлбөрийн	8,840,017,887.57		8,840,017,887.57
Урт хугацаат зээл			-
Бусад урт хугацаат өр төлбөр			-
төлбөрийн дүн	-		-
Өр төлбөрийн нийт дүн	8,840,017,887.57		8,840,017,887.57
Эзэмшигчийн өмч			
Өмч: а) Төрийн	837,779,515.45		837,779,515.45
б) Хувийн			-
Нэмж төлөгдсөн капитал	208,346,414.91		208,346,414.91
Хуримтлагдсан ашиг (алдагдал)	(1,008,400,537.88)		2,028,165,569.21
Өмнөх үеийн	2,029,698,345.14		2,029,698,345.14
Тайлангийн үеийн	(3,038,098,883.02)	3,036,566,107.09	(1,532,775.93)
Эзэмшигчийн өмч	37,725,392.48	3,036,566,107.09	3,074,291,499.57
Өр төлбөр ба эзэмшигчийн өмчийн дүн	8,877,743,280.05	3,036,566,107.09	11,914,309,387.14

"ХИЛИЙН ЦЭРГИЙН 0119 ДУГААР АНГИ" ТӨААТҮГ

**2016 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН АУДИТЛАГДСАН ОРЛОГО,
ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН**

(төгрөгөөр)

Үзүүлэлтүүд	2016-12-31		
	Аудитлагдаагүй	Залруулга	Аудитлагдсан
Борлуулалтын орлого	2,956,579,457.14		2,956,579,457.14
Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	5,157,450,770.13	(3,036,566,107.09)	2,120,884,663.04
Нийт ашиг (алдагдал)	(2,200,871,312.99)	(3,036,566,107.09)	835,694,794.10
Үйл ажиллагааны зардал			
Түрээсийн орлого			-
Хүүгийн орлого	453,554.82		453,554.82
Ноогдол ашгийн орлого			-
Эрхийн шимтгэлийн орлого			-
Бусад орлого	10,185.57		10,185.57
Орлогын дүн	463,740.39		463,740.39
Борлуулалт маркетингийн зардал	357,256.88		357,256.88
Ерөнхий ба удирдлагын зардал	784,226,782.54		784,226,782.54
Санхүүгийн зардал			-
Бусад зардал	53,107,271.00		53,107,271.00
Зардлын дүн	837,691,310.42	-	837,691,310.42
Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)			-
Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)			-
Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)			-
Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)			-
Бусад ашиг (алдагдал)			-
Олз, гарзын дүн	-		-
Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	(3,038,098,883.02)	3,036,566,107.10	(1,532,775.93)
Орлогын татварын зардал			
Татварын дараах ашиг (алдагдал)	(3,038,098,883.02)	3,036,566,107.10	(1,532,775.93)
Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)			
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	(3,038,098,883.02)	3,036,566,107.10	(1,532,775.93)
Бусад дэлгэрэнгүй орлого			
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэлийн зөрүү	-		-
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү			

Бусад олз (гарз)

Орлогын нийт дүн

(3,038,098,883.02)

3,036,566,107.10

(1,532,775.93)

"ХИЛИЙН ЦЭРГИЙН 0119 ДУГААР АНГИ" ТӨААТҮГ

**2016 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН ЖИЛИЙН
АУДИТЛАГДСАН ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН**

(төгрөгөөр)

Үзүүлэлт	Өмч	Нэмж төлөгдсөн капитал	Хуримтлагдсан ашиг (алдагдал)	Нийт дүн
2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	753,163,135.05	208,346,414.91	2,019,132,866.81	2,980,642,416.77
Бүртгэлийн бодлогын өөрчлөлт				-
Өмчид гарсан өөрчлөлт	84,616,380.40			84,616,380.40
Өмнөх залруулсан үлдэгдэл		-	-	-
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт (бууралт)				-
Хөрөнгө оруулалтын дахин үнэлгээний өсөлт (бууралт)				-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				-
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)			10,565,478.33	10,565,478.33
Ногдол ашиг				-
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн			-	-
2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	837,779,515.45	208,346,414.91	2,029,698,345.14	3,075,824,275.50
Бүртгэлийн бодлогын өөрчлөлт				-
Өмчид гарсан өөрчлөлт		-		-
Өмнөх залруулсан үлдэгдэл		-	-	-
Хөрөнгө оруулалтын дахин үнэлгээний өсөлт (бууралт)				-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				-
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)			(1,532,775.93)	(1,532,775.93)
Ногдол ашиг				-
Гаргасан хувьцаат капитал				-
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн			-	-
2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	837,779,515.45	208,346,414.91	2,028,165,569.21	3,074,291,499.57

"ХИЛИЙН ЦЭРГИЙН 0119 ДУГААР АНГИ" ТӨААТҮГ

**2016 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН ЖИЛИЙН МӨНГӨН
ГҮЙЛГЭЭНИЙ АУДИТЛАГДСАН ТАЙЛАН**

(мянган төгрөг)

Үзүүлэлтүүд	2016-12-31	
	Аудитлагдаагүй	Аудитлагдсан
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
<u>Үндсэн үйл ажиллагааны мөнгөн орлого</u>	7,445,040,918.88	7,445,040,918.88
Борлуулалтын болон худалдан авагчдаас орсон мөнгө	7,445,030,733.31	7,445,030,733.31
Туслах үйл ажиллагаанаас орсон мөнгөн орлого		-
Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө		-
Буцаан авсан албан татвар		-
Бусад мөнгөн гүйлгээ	10,185.57	10,185.6
<u>Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн зардал</u>	5,792,931,540.24	5,792,931,540.24
Ажиллагсдад олгосон мөнгө	784,929,184.00	784,929,184.0
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн мөнгө	82,600,000.00	82,600,000.0
Ашиглалтын зардалд төлсөн	341,544,025.56	341,544,025.6
Бараа материал худалдан авахад төлсөн мөнгө	3,937,917,498.23	3,937,917,498.2
Шатахуун, сэлбэг хэрэгсэлд төлсөн мөнгө	13,194,730.00	13,194,730.0
Татварын байгууллагад төлсөн	125,010,794.00	125,010,794.0
Даатгалын төлбөрт төлсөн	10,165,252.00	10,165,252.0
Хүүний төлбөрт төлсөн	301,717,620.74	301,717,620.7
Бусад	195,852,435.71	195,852,435.7
<u>Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ</u>	1,652,109,378.6	1,652,109,378.6
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		-
Мөнгөн орлогын дүн (+)	453,554.8	453,554.8
Үндсэн хөрөнгө борлуулсаны орлого		-
Биет бус хөрөнгө борлуулсаны орлого		-
Хүлээн авсан хүүний орлого	453,554.82	453,554.8
Мөнгөн зарлагын дүн (-)	-	-
Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		-
Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		-
Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн		-
Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		-
Бусдад олгосон зээл болон урьдчилгаа		-
<u>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ</u>	453,554.82	453,554.8
Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		-
Мөнгөн орлогын дүн (+)	-	-
Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		-
Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		-
Бусад		-
Мөнгөн зарлагын дүн (-)	1,658,224,387.12	1,658,224,387.12
Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн	1,658,224,387.12	1,658,224,387.12
Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн		-
<u>Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ</u>	(1,658,224,387.12)	(1,658,224,387.12)
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(5,661,453.66)	(5,661,453.66)
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	6,972,204.22	6,972,204.22
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,310,750.56	1,310,750.56